



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/94

Бат-Өлзий сум

Гэрээ байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.4, 46.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Бат-Өлзий сумын Улиастай багийн зам засварын ажлыг иргэн Б.Түвшинжаргалтай шууд худалдан авах аргаар гэрээ байгуулсугай.

2. Иргэн Б.Түвшинжаргалтай гэрээ байгуулж, зам засварын ажлын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Орхонтуул)-д даалгасугай.

3. Улиастай багийн зам засварын ажлын 10,000,000 (арван сая) төгрөгийн санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн авч, гэрээний дагуу, Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН